



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 10 сарын 12 өдөр

Дугаар А/348

Мөрөн сум

Захирамжид өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 66.3 дахь хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтын вакцин ирэх хугацаа хойшлогдож, хуваарь дахин батлагдсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2022 оны 09 дүгээр сарын 16-ний өдрийн “Малын гоц халдварт шүлхий өвчний дархлаажуулалтын ажлыг зохион байгуулах тухай” А/316 дугаар захирамжийн 1 дэх заалтын “2022 оны 09 дүгээр сарын 21-ний өдрөөс эхлэн 20 хоногийн хугацаанд зохион байгуулсугай гэснийг” 2022 оны 09 дүгээр сарын 26-ны өдрөөс эхлэн 44 хоногийн хугацаанд зохион байгуулсугай гэж өөрчилсүгэй.

2. Дархлаажуулалтын хугацаанд өөрчлөлт оруулсан захирамжийг сумдын Засаг дарга нарт хүргүүлж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Мал эмнэлгийн газар (Д.Нямдорж)-т даалгасугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (П.Ариунбат)-т үүрэг болгосугай.

ДАРГА



Ш.ИДЭРБАЯСГАЛАН